



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням

Утас:70432545 Цахим хаяг:
Damiranbaljinnyam573@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1. Төлбөрийн акт	11
3.2 Зөвлөмж.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЭМГ	Эрүүл мэндийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.23 № 115

танай _____ -ны № _____ -т

ҮЕНЧ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ
У.УУГАНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Онцлох асуудал нь тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл 84.4 сая төгрөг, үүний 12.7 сая төгрөг нь он дамжсан үлдэгдэл байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8426050221

Тайлант онд урсгал төсвөөс 31.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, харьяа дээд шатны байгууллага болон хандив тусламжаар 29.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Бусад асуудал

Үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 хөтөлбөр, 7 зорилтын хүрээнд 78 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 92.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Х.БОЛДБААТАР**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>241,152,594.46</u>	<u>174,892,585.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,963,229.27	45,376,788.33
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,963,229.27	45,376,788.33
3121	Төгрөг	11,963,229.27	45,376,788.33
31211	Төрийн сангийн харилцах	11,963,229.27	45,376,788.33
33	АВЛАГА	153,070,644.82	40,377,226.19
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	506,546.14
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	152,770,644.82	39,870,680.05
35	БАРАА МАТЕРИАЛ	76,118,720.37	89,138,570.76
351	Түүхий эд материал	72,123,113.20	84,379,863.59
35130	Эм боох материал	72,123,113.20	84,379,863.59
354	Хангамжийн материал	3,995,607.17	4,758,707.17
35410	Бичиг хэргийн материал	72,000.00	340,500.00
35420	Аж ахуйн материал	-	643,200.00
35460	Хүнсний материал	861,000.00	102,400.00
35470	Бусад хангамжийн материал	3,062,607.17	3,672,607.17
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>877,496,404.96</u>	<u>850,229,109.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	877,496,404.96	850,229,109.80
392	Биет хөрөнгө	865,496,404.96	838,229,109.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	401,813,364.60	678,138,990.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(89,687,686.17)	(100,834,969.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,533,738.00	133,533,738.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(90,607,146.39)	(108,202,386.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	324,518,376.67	379,329,176.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(112,819,039.96)	(197,914,944.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,993,563.40	92,923,563.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,808,785.19)	(38,744,059.15)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	235,560,020.00	-
393	Биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,118,648,999.42</u>	<u>1,025,121,695.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>206,546.14</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	206,546.14
413	Өглөг	-	206,546.14
4136	Бусад өглөг	-	206,546.14
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	206,546.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,118,648,999.42</u>	<u>1,024,915,148.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,118,648,999.42	1,024,915,148.94

Үенч сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	247,668,384.00	247,668,384.00
51101	Өмч: - төрийн	247,668,384.00	247,668,384.00
512	Хуримтлагдсан үр дүн	610,959,820.75	517,225,970.27
51210	Өмнөх үеийн үр дүн	610,959,820.75	610,959,820.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	(93,733,850.48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	260,020,794.67	260,020,794.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,118,648,999.42</u>	<u>1,025,121,695.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	(Төгрөгөөр)		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,589,635,735.26	1,442,007,174.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	334,029,922.47	111,426,119.15
120	Нийтлэг татварын бус орлого	334,029,922.47	111,426,119.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	334,029,922.47	111,426,119.15
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	36,839,747.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	334,029,922.47	74,586,372.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,255,605,812.79	1,330,581,054.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,651,600.00	53,804,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,651,600.00	53,804,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,201,954,212.79	1,276,776,254.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,201,954,212.79	1,276,776,254.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,272,283,747.52	1,535,741,024.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,272,283,747.52	1,535,741,024.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,271,351,547.52	1,501,568,373.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	798,087,128.40	968,348,881.44
210101	Үндсэн цалин	357,998,310.21	374,849,881.65
210102	Нэмэгдэл	340,801,932.00	459,808,666.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,452,000.00	63,070,000.00
210104	Урамшуулал	64,834,886.19	70,620,333.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,243,104.81	122,375,231.27
210201	Тэтгэврийн даатгал	69,327,946.42	83,290,280.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,959,221.15	9,757,241.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,399,450.24	5,263,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,002,820.00	5,263,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,553,667.00	18,801,509.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,461,300.00	49,966,148.56
210301	Гэрэл, цахилгаан	4,659,604.99	4,212,842.30

**Үенч сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	39,551,695.01	45,363,306.26
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	390,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,295,670.00	66,628,337.00
210401	Бичиг хэрэг	6,225,700.00	5,900,300.00
210402	Тээвэр, шатахуун	35,040,900.00	47,628,215.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,573,520.00	3,236,592.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,446,150.00	2,582,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,009,400.00	7,280,950.00
2105	Нормативт зардал	127,776,169.33	112,522,211.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,805,889.33	96,828,611.66
210502	Хоол, хүнс	13,470,280.00	12,657,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	3,036,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,566,500.08	21,262,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,363,300.08	1,556,000.00
210604	Урсгал засвар	15,203,200.00	19,706,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,158,000.00	2,920,000.00
210702	Дотоод албан томилолт	2,158,000.00	2,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,961,542.00	9,029,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,520,142.00	8,281,460.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	77,860.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,802,132.90	148,516,243.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,493,150.04	19,742,542.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,308,982.86	128,773,701.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	932,200.00	34,172,651.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,534,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	33,534,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	638,651.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	638,651.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>317,351,987.74</u>	<u>(93,733,850.48)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>317,351,987.74</u>	<u>(93,733,850.48)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	(Төгрөгөөр)	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,119,039,977.97</u>	<u>1,480,320,766.67</u>

Үенч сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	36,839,747.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	36,839,747.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	36,839,747.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	36,839,747.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,119,039,977.97	1,443,481,019.67
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,651,600.00	53,804,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,651,600.00	53,804,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,065,388,377.97	1,389,676,219.67
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,065,388,377.97	1,389,676,219.67
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,180,038,057.72	1,415,385,507.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,180,038,057.72	1,415,385,507.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,179,105,857.72	1,381,212,856.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	797,742,301.19	968,348,881.44
210101	Үндсэн цалин	357,653,483.00	374,849,881.65
210102	Нэмэгдэл	340,801,932.00	459,808,666.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,452,000.00	63,070,000.00
210104	Урамшуулал	64,834,886.19	70,620,333.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,865,980.02	122,375,231.27
210201	Тэтгэврийн даатгал	69,248,146.02	83,290,280.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,959,217.00	9,757,241.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,102,700.00	5,263,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,002,850.00	5,263,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,553,067.00	18,801,509.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,461,300.00	49,966,148.56
210301	Гэрэл, цахилгаан	4,659,604.99	4,212,842.30
210302	Түлш, халаалт	39,551,695.01	45,363,306.26
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	390,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,278,070.00	67,578,607.00
210401	Бичиг хэрэг	6,218,500.00	6,128,800.00
210402	Тээвэр, шатахуун	35,040,900.00	47,628,215.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,573,520.00	3,236,592.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,445,150.00	2,585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	8,000,000.00
2105	Нормативт зардал	108,588,864.51	121,588,977.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,956,084.51	106,653,977.90
210502	Хоол, хүнс	14,132,780.00	11,899,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	3,036,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,680,300.00	22,499,000.00

Үенч сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	20,477,100.00	2,299,000.00
210604	Урсгал засвар	15,203,200.00	20,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,158,000.00	2,920,000.00
210702	Дотоод албан томилолт	2,158,000.00	2,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,961,142.00	9,029,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,520,142.00	8,281,460.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	77,860.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	286,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,369,900.00	16,906,690.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,369,900.00	16,906,690.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	932,200.00	34,172,651.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,534,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	33,534,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	638,651.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	638,651.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(60,998,079.75)	64,935,259.06
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	31,521,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	31,521,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	31,521,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	31,521,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(31,521,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(60,998,079.75)	33,413,559.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,963,229.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,963,229.27	45,376,788.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,668,384.00	260,020,794.67	610,959,820.75	1,118,648,999.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,668,384.00	260,020,794.67	610,959,820.75	1,118,648,999.42
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,668,384.00	260,020,794.67	610,959,820.75	1,118,648,999.42

Үенч сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	247,668,384.00	260,020,794.67	610,959,820.75	1,118,648,999.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,668,384.00	260,020,794.67	610,959,820.75	1,118,648,999.42
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(93,733,850.48)	(93,733,850.48)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,668,384.00	260,020,794.67	517,225,970.27	1,024,915,148.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,564,429,300.00	1,446,268,556.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,564,429,300.00	1,446,268,556.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,529,155,300.00	1,412,734,556.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,032,098,000.00	968,348,881.44
210101	Үндсэн цалин	408,714,600.00	374,849,881.65
210102	Нэмэгдэл	485,743,400.00	459,808,666.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,640,000.00	63,070,000.00
210104	Урамшуулал	69,000,000.00	70,620,333.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,645,600.00	122,375,231.27
210201	Тэтгэврийн даатгал	86,540,700.00	83,290,280.45
210202	Тэтгэмжийн даатгал	10,526,300.00	9,757,241.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,263,100.00	5,263,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,263,100.00	5,263,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,052,400.00	18,801,509.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,604,800.00	49,966,148.56
210301	Гэрэл, цахилгаан	6,380,300.00	4,212,842.30
210302	Түлш, халаалт	43,834,500.00	45,363,306.26
210303	Цэвэр, бохир ус	390,000.00	390,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,845,100.00	67,578,607.00
210401	Бичиг хэрэг	6,893,700.00	6,128,800.00
210402	Тээвэр, шатахуун	54,920,000.00	47,628,215.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,446,400.00	3,236,592.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,585,000.00	2,585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,000,000.00	8,000,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	140,889,100.00	121,588,977.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,786,400.00	106,653,977.90
210502	Хоол, хүнс	15,602,700.00	11,899,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	3,036,000.00

Үенч сумын Эрүүл мэндийн төвий 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,784,100.00	49,414,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,584,100.00	29,214,800.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	
210604	Урсгал засвар	20,200,000.00	20,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	2,920,000.00
210701	Гадаад албан томиллолт		
210702	Дотоод албан томиллолт	6,000,000.00	2,920,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,010,000.00	11,429,320.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,641,500.00	10,681,460.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	77,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,551,000.00	220,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,462,500.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,278,600.00	19,112,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,278,600.00	19,112,590.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,274,000.00	33,534,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,274,000.00	33,534,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,274,000.00	33,534,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,563,790,648.56	1,479,682,115.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	53,166,148.56	53,166,148.56
132001	Орон нутгийн төсвөөс	53,166,148.56	53,166,148.56
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,461,305,100.00	1,389,676,219.67
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,461,305,100.00	1,389,676,219.67
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	49,319,400.00	36,839,747.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,356,100.00	36,839,747.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	11,963,300.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,963,229.27
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		45,376,788.33

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар өөрийн хөрөнгөөр худалдаж авсан өрөөний шилэн хаалтыг данс бүртгэлд тусгаагүй нийт 5,100.0 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 16,209.5 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил² илэрсэнд 2,519.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 13,690.2 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны дүн нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 16,994.5 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1. Төлбөрийн акт

3.1.1 Байгууллагын ажиллагсад олгосон илүү цагийн тооцоог хянаж үзэхэд 2 сувилагчид ажиллаагүй хугацаанд нь илүү цагийн хөлс бодож олгосонтой холбоотой 819.0 мянган төгрөг, байгууллагын нягтлан бодогчид балансын урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосонтой холбоотой 1,240.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Тайлант онд зарцуулсан эмийг анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 499 ширхэг 460.3 мянган төгрөгийн цагийн тариаг илүү зарлага гаргасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг зарлагадахдаа эхэлж авснаа эхэлж зарлагадаагүй, ижил нэр төрөл үнэ бүхий эмийг өөр кодоор бүртгэсэн, тайлант онд 16 нэр төрлийн 62053 ширхэг эм, эмнэлгийн хэрэгслийг их хэмжээгээр авч нөөцөлсөн, эмийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захиалга хүргүүлэхдээ судалгаанд үндэслээгүйгээс ЭМГ-т нэр бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг хэрэгцээнээс илүү хүргүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"; 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д "Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.", 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад хяналт тавих, хэрэгцээнээс илүү хэмжээгээр нөөцлөхгүй, эмийн захиалгыг судалгаанд үндэслэн хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Өөрийн хөрөнгөөр худалдаж авсан өрөөний шилэн хаалтыг данс бүртгэлд тусгаагүй	1	5,100.0	1	5,100.0	0	0	1	5,100.0		
Нийт дүн	1	5,100.0	1	5,100.0	0	0	1	5,100.0		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг зарлагдахдаа эхэлж авснаа эхэлж зарлагдаагүй, ижил нэр төрөл үнэ бүхий эмийг өөр кодоор бүртгэсэн, тайлант онд 16 нэр төрлийн 62053 ширхэг эм, эмнэлгийн хэрэгслийг их хэмжээгээр авч нөөцөлсөн, эмийн захиалга хүргүүлэхдээ судалгаанд үндэслээгүйгээс ЭМГ-т нэр бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг хэрэгцээнээс илүү хүргүүлсэн	1	13,690.2					1	13,690.2
Байгууллагын ажиллагсдад олгосон илүү цагийн тооцоог хянаж үзэхэд 2 сувилагчид ажиллаагүй хугацаанд нь илүү цаг бодож олгосон	1	819.0	1	819.0				
Байгууллагын ажиллагсдад олгосон цалингийн нэмэгдлүүдийг шалгаж үзэхэд байгууллагын нягтлан бодогчид улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшууллыг олгосон		1,240.0		1,240.0				
Тайлант онд зарцуулсан эмийг анхан шатны баримттай тулган шалгахад 5 нэр төрлийн 499 ширхэг цагийн тариаг илүү зарлага гаргасан	1	460.3	1	460.3				
	3	16,209.5	2	2,519.3			1	13,690.2

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			